

ДИЖИТАЛ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү “Дижитал банкны үйлчилгээ үзүүлэх гэрээ” (цаашид “Дижитал Банкны гэрээ” гэх)-г нэг талаас Голомт Банк, нөгөө талаас

Овог

Нэр

Регистрийн №

Утас

И-мэйл хаяг

(цаашид “Харилцагч” гэх, хамтад нь “Талууд” гэх) нар Монгол Улсын Иргэний Хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нийцүүлэн харилцан тохиролцож байгуулав.

- 1.2. Энэхүү Дижитал банкны гэрээгээр Банк нь Харилцагчид зайны сувгаар дамжуулан бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний нөхцөлийг тодорхойлох харилцааг зохицуулах бөгөөд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.
- 1.3. Энэхүү гэрээ нь Харилцагч болон Банкны хооронд байгуулагдсан Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх ерөнхий гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд тухайн гэрээнд тусгагдсан үйлчилгээний нөхцөлийг энэхүү гэрээнд мөн дагаж мөрдөнө.

ХОЁР. ЗАЙНААС БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

- 2.1. Энэхүү гэрээний дагуу зайны сувгаар дамжуулан Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авах хүсэлтэй байгаа Харилцагч нь Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх гэрээг Банктай байгуулж, тухайн гэрээнд заасны дагуу Харилцагчийг таних, баталгаажуулахад шаардлагатай аливаа мэдээллийг бүрэн гаргаж өгсөн байх шаардлагатай.
- 2.2. Дараах сувгуудыг Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэх боломжтой зайны суваг гэж тооцно. Үүнд:
- 2.2.1. Интернет банк болон смарт банкны үйлчилгээ;
 - 2.2.2. Сошиал пэй үйлчилгээ;
 - 2.2.3. Мобайл банкны үйлчилгээ;
 - 2.2.4. Киоск төхөөрөмж;
 - 2.2.5. Лавлах төвөөс үзүүлэх үйлчилгээ;
 - 2.2.6. Банкны албан ёсны цахим хуудсаар дамжуулан үзүүлэх үйлчилгээ;
 - 2.2.7. Банкнаас тодорхойлсон бусад суваг.
- 2.3. Банкны албан ёсны цахим хуудас www.golomtbank.com-д тусгагдсан, нийтэд ил тод зарласан Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөлүүд болон үйл ажиллагааны нийтлэг зохицуулалтыг Банкны үйлчилгээний ерөнхий нөхцөл гэж тооцох ба ерөнхий нөхцөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 2.4. Банкнаас зайны сувгаар үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөлийг Банкны ерөнхий нөхцөлөөр тодорхойлно.
- 2.5. Банк өөрийн зарласан ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулж болох бөгөөд холбогдох өөрчлөлтийн тухай мэдээллийг тухайн өөрчлөлтийг дагаж мөрдөж эхлэхээс 30 хоногийн өмнө нийтэд ил тод зарлана. Харилцагч энэ хугацаанд өөрчлөлт оруулсан нөхцөлөөс татгалзаж, энэ гэрээг дуусгавар болгох тухай санал гаргаагүй тохиолдолд өөрчлөлт оруулсан нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- 2.6. Зайны сувгаар дамжуулан данс нээх, хадгаламж нээх, карт олгох зэрэг бүтээгдэхүүн үйлчилгээ шинээр үзүүлж байгаа тохиолдолд тухайн бүтээгдэхүүн үйлчилгээний нэмэлт нөхцөлийг тусгасан үйлчилгээний нэмэлт гэрээг дижитал хэлбэрээр байгуулна.

Харилцагчийн баталгаа, зөвшөөрөл

- 2.7. Харилцагч нь энэхүү гэрээний нөхцөлтэй бүрэн танилцаж, гэрээ байгуулсантай холбогдуулан бий болох хууль, эрх зүйн үр дагаврыг бүрэн ойлгосон болно.
- 2.8. Харилцагч нь Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авсантай холбогдуулан төлбөл зохих үйлчилгээний шимтгэл, хураамжийг Банкны нийтэд зарласан ерөнхий нөхцөлийн дагуу төлөхийг үүгээр зөвшөөрч байгаа бөгөөд холбогдох шимтгэл, хураамжийг Харилцагчийн данснаас суутган авахыг Банканд даалгаж/зөвшөөрч байна.

- 2.9. Харилцагч нь зайны сувгаар үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээ нь тодорхой хязгаарлалттай байхыг зөвшөөрсөн бөгөөд зайны сувгаар дамжуулан үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой үүсч болох аливаа эрсдэлийг ойлгож, тухайн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг тухай бүр авч ажиллахаа үүгээр мэдэгдэж байна.
- 2.10. Зайны сувгаар үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээ нь Харилцагчийн Банканд бүртгэлтэй и-мэйл хаяг, гар утасны дугаар, Харилцагчийн эзэмшлийн ухаалаг утас, интернэт банкны нэвтрэх нэр, нууц үг, батлах нууц үг, бусад бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулах нууц код зэрэгт үндэслэх болохыг ойлгож хүлээн зөвшөөрч байна. Харилцагч нь эдгээр мэдээллийг чандлан нууцалж, гуравдагч этгээдэд дамжуулахгүй бөгөөд бусдад алдахаас сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авч байх болохоо үүгээр баталж байна.

ГУРАВ. ЗАЙНААС БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

Зайны сувгаар төлбөр тооцоо гүйцэтгэх

- 3.1. Зайны сувгаар төлбөр тооцоо гүйцэтгэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:
- 3.1.1. Харилцагч нь тухайн зайны сувгаар дамжуулан гүйцэтгэж буй төлбөр тооцооны үйлчилгээний нөхцөл, шимтгэл, хураамжийн хэмжээг танилцсан байна.
- 3.1.2. Харилцагч нь тухайн төлбөрийн даалгаврыг гүйцэтгэх, үйлчилгээний шимтгэл, хураамжийг төлөхөд хангалттай хэмжээний мөнгөн хөрөнгийг дансанд байршуулсан байна.
- 3.1.3. Хийгдсэн төлбөр тооцооны мэдээллийг гүйлгээ хийсэн зайны суваг болон бусад боломжит сувгаар дамжуулан шалгаж, баталгаажуулж байна.
- 3.1.4. Зайны сувгаар өгч буй төлбөрийн даалгаврыг интернэт банкны нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг, шаардлагатай тохиолдолд батлах нууц үг, интернэт банкны нууцлалын төхөөрөмж, сошиал пэй үйлчилгээний нууц код, мобайл банкны нууц код зэргээр баталгаажуулах бөгөөд эдгээрийг Харилцагчийн баталгаат гарын үсэгтэй адилтгаж авч үзнэ.
- 3.2. Зайны сувгаар Харилцагчийн хүсэлтийн дагуу харилцах данс нээх үед дараах зарчмыг баримтална. Үүнд:
- 3.2.1. Харилцагчийн хүсэлтийг зайны сувгаар хүлээн авсан тохиолдолд Банк харилцах дансыг нээж, тухайн харилцах дансны дугаар болон бусад нөхцөлийг тусгасан Үйлчилгээний нэмэлт гэрээг Харилцагч өөрийн дижитал сувгаар танилцана.
- 3.2.2. Харилцагч нь дижитал хэлбэрээр танилцуулсан Үйлчилгээний нэмэлт гэрээтэй бүрэн, гүйцэд танилцах үүрэгтэй ба тухайн гэрээний нөхцөлийг зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд энэ тухай Банканд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
- 3.2.3. Харилцагчийн зүгээс татгалзсан хариу ирүүлээгүй тохиолдолд Үйлчилгээний нэмэлт гэрээний нөхцөлийг зөвшөөрсөнд тооцож, харилцах дансны үйлчилгээг идэвхжүүлнэ.
- 3.3. Зайны сувгаар Харилцагчийн хүсэлтийн дагуу биет болон биет бус карт олгож байгаа бол талууд дараах зарчмыг баримтална. Үүнд:
- 3.3.1. Харилцагчийн хүсэлтийг зайны сувгаар хүлээн авсны дараа картын дугаарыг үүсгэж, тухайн картын дугаар болон картын үйлчилгээний нөхцөлийг тодорхойлсон Үйлчилгээний нэмэлт загварыг дижитал сувгаар харуулна.
- 3.3.2. Харилцагч нь дижитал сувгаар харуулж буй үйлчилгээний нэмэлт загвартай танилцах үүрэгтэй ба тухайн загварын нөхцөлийг зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд энэ тухай нэн даруй Банканд мэдэгдэх үүрэгтэй.
- 3.3.3. Банк нь Харилцагчаас татгалзсан хариу ирээгүй тохиолдолд картыг хэвлэн бэлтгэж, Харилцагчийн хүсэлт гаргасан арга, хэлбэрийн дагуу картыг хүлээлгэн өгнө.
- 3.3.4. Харилцагч нь карт авах хүсэлт гаргахдаа картыг хүлээн авах салбарын мэдээллийг эсхүл хүргэлтээр хүргүүлэх захиалгыг гаргах үүрэгтэй..
- 3.3.5. Харилцагч зайны сувгаар захиалсан картын нөхцөл нь Банкны картын үйлчилгээний Ерөнхий нөхцөлөөр тодорхойлогдоно.
- 3.3.6. Зайны сувгаар захиалсан дебит картын хураамжийг картын захиалга хийх тухай бүр Харилцагчийн харилцах данснаас суутган авна.
- 3.3.7. Зайны сувгаар захиалсан кредит картын жилийн хураамжийг харилцагч картаа хүлээн авч, идэвхжүүлсэн өдөр зээлийн эрхээс авто суутгана.
- 3.3.8. Карт хүргэлтийн үйлчилгээний шимтгэл хураамжийг картын ерөнхий нөхцөлд заасны дагуу Харилцагчийн харилцах данснаас суутган авна.
- 3.3.9. Харилцагч нь картыг өөрийн биеэр хүлээн авсны дараа зайны сувгаар дамжуулан картыг идэвхжүүлэх ба ийнхүү идэвхжүүлснээр тухайн картаар төлбөр тооцоо гүйцэтгэх боломжтой болно.

- 3.3.10. Харилцагч нь биет бус төлбөрийн карт нээлгэх хүсэлт гаргасан бол биет бус карт нь Харилцагчийн бүртгэлтэй Сошиал пэй хэтэвчинд бүртгэгдэнэ.
- 3.3.11. Биет бус карт нь картын бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцөл болон бүтээгдэхүүн үйлчилгээний гэрээний дагуу зохицуулагдана.

Зайны сувгаар хадгаламжийн үйлчилгээ үзүүлэх

- 3.4. Зайны сувгаар Харилцагчийн хүсэлтийн дагуу хугацаагүй хадгаламжийн данс нээж байгаа тохиолдолд дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 3.4.1. Харилцагчийн хүсэлтийг зайны сувгаар хүлээн авсан тохиолдолд Банк хугацаагүй хадгаламжийн дансыг нээж, хугацаагүй хадгаламжийн дансны дугаар болон бусад нөхцөлийг тусгасан Үйлчилгээний нэмэлт гэрээг Харилцагчид дижитал хэлбэрээр хүргүүлнэ.
 - 3.4.2. Харилцагч нь дижитал хэлбэрээр хүргүүлсэн Үйлчилгээний нэмэлт гэрээтэй танилцах үүрэгтэй ба тухайн гэрээний нөхцөлийг зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд энэ тухай Банканд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
 - 3.4.3. Харилцагчийн зүгээс татгалзсан хариу ирүүлээгүй тохиолдолд Үйлчилгээний нэмэлт гэрээний нөхцөлийг зөвшөөрсөнд тооцож, хадгаламжийн дансыг нээх бөгөөд Харилцагч нь тухайн дансанд хугацаагүй хадгаламжийн дансны хамгийн доод үлдэгдлийг байршуулах үүрэг хүлээнэ.
- 3.5. Зайны сувгаар Харилцагчийн хүсэлтийн дагуу хугацаатай хадгаламжийн данс нээж байгаа тохиолдолд дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 3.5.1. Харилцагчийн хүсэлтийг зайны сувгаар хүлээн авсан тохиолдолд Банк хугацаатай хадгаламжийн дансыг нээж, хугацаатай хадгаламжийн дансны дугаар болон бусад нөхцөлийг тусгасан Үйлчилгээний нэмэлт гэрээг Харилцагчид дижитал хэлбэрээр хүргүүлнэ.
 - 3.5.2. Харилцагч нь дижитал хэлбэрээр хүргүүлсэн Үйлчилгээний нэмэлт гэрээтэй танилцах үүрэгтэй ба тухайн гэрээний нөхцөлийг зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд энэ тухай Банканд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
 - 3.5.3. Харилцагчийн зүгээс татгалзсан хариу ирүүлээгүй тохиолдолд Үйлчилгээний нэмэлт гэрээний нөхцөлийг зөвшөөрсөнд тооцож, хадгаламжийн дансыг нээнэ.
 - 3.5.4. Харилцагч нь шинээр нээгдсэн хугацаатай хадгаламжийн дансанд энэхүү гэрээнд Үйлчилгээний нэмэлт гэрээнд заасан нөхцөлийн дагуу орлогын гүйлгээ хийж болно.
 - 3.5.5. Зайны сувгаар нээгдсэн хадгаламжийн дансыг хаах, тухайн хадгаламжийн данснаас зарлагын гүйлгээ гаргах тохиолдолд Харилцагч нь Банкны аль нэг салбар, тооцооны төвд өөрийн биеэр ирж Үйлчилгээний нэмэлт гэрээг бичгээр байгуулж, баталгаажуулсан байх шаардлагатай бөгөөд уг шаардлагыг биелүүлээгүйгээс болж үүсч болох эрсдэлийг Банк хариуцахгүй.
 - 3.5.6. Банк нь хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий этгээдийн шийдвэрээр эсхүл Харилцагчтай байгуулсан бусад гэрээний үндсэн дээр түүний зайны сувгаар нээсэн хугацаатай болон хугацаагүй хадгаламжийн данснаас зарлагын гүйлгээ хийх тохиолдолд энэ гэрээний 3.5.5-д заасан нөхцөлийг баримтлахгүй байж болно.

Үйлчилгээний хязгаарлалт

- 3.6. Дараах тохиолдолд Банк Харилцагчид зайны сувгаар бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж болно. Үүнд:
 - 3.6.1. Харилцагч нь Банканд гаргаж өгвөл зохих мэдээллийг гаргаж өгөөгүй эсхүл хувийн хэргийн бүрдэл дутуу байгаа тохиолдолд;
 - 3.6.2. Харилцагчийн Банканд гаргаж өгсөн мэдээлэл нь хуурамч мэдээлэл болох нь тогтоогдсон;
 - 3.6.3. Харилцагч нь Лавлах төвд өөрийн бүртгэлгүй утасны дугаар болон и-мэйл хаягаас холбогдож, интернэт банкны үйлчилгээ авах хүсэлт гаргасан тохиолдолд;
 - 3.6.4. Харилцагч нь Банкнаас шаардсан мэдээлэл, баримт бичгийг гаргаж өгөхөөс татгалзсан;
 - 3.6.5. Харилцагчийн үйл ажиллагаа, гүйлгээ нь Банкны дотоод бодлого, журмын дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй гэж тооцогдсон;
 - 3.6.6. Харилцагч нь энэхүү гэрээнд заасан зохих ёсоор биелүүлээгүй эсхүл биелүүлэхээс татгалзах зөрчил удаа дараа бий болсон;
 - 3.6.7. Харилцагч бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа болохоо илэрхийлсэн;
 - 3.6.8. Харилцагч нь Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг 2 болон түүнээс дээш жилийн хугацаанд ашиглаагүй;
 - 3.6.9. Харилцагч нас барсан, ор сураггүй алга болсон эсхүл нас барсан гэж эрх бүхий байгууллагаас тогтоогдсон болохыг нотлох баримтыг Банканд ирүүлсэн тохиолдолд Банкны санаачлагаар;
 - 3.6.10. Аливаа шалтгааны улмаас Банк энэхүү гэрээнд заасан бүтээгдэхүүн, үйлчилгээг цаашид үзүүлэх боломжгүй нөхцөл байдал бий болсон бол энэ тухай Харилцагчид мэдэгдсэнээр

ДӨРӨВ. ИНТЕРНЭТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

- 4.1. Интернэт банкны үйлчилгээ гэдэг нь банкны тодорхой төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг дижитал хэлбэрээр үзүүлэх зориулалт бүхий харилцагчийн нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг, батлах нууц үг эсхүл нууцлал бүхий төхөөрөмжөөр хамгаалагдсан Харилцагчид зориулсан үйлчилгээ юм.
- 4.2. Интернэт банкны үйлчилгээг Банкны албан ёсны цахим хуудсаар дамжуулан авна. Үүнд: www.egolomt.mn
- 4.3. Интернэт банкны үйлчилгээний нөхцөл нь Банкны нийтэд зарласан Ерөнхий нөхцөлөөр тодорхойлогдоно.
- 4.4. Интернэт банкны үйлчилгээг Харилцагч Банкны аль нэг салбар, тооцооны төв дээр очиж нээлгэнэ.
- 4.5. Харилцагч гэрээнд заасан, зөвшөөрөгдсөн зайны сувгаар дамжуулан Интернэт банк нээлгэх хүсэлтийг холбогдох материалын хамт бүрдүүлж илгээсэн тохиолдолд Банк Харилцагчид Интернэт банкны эрхийг нээж болно.
- 4.6. Интернэт банкны үйлчилгээний хүсэлтийг хүлээн авах боломжтой гэж үзсэн тохиолдолд Банк Интернэт банкны үйлчилгээнд ашиглах нэвтрэх нэр болон системээс автоматаар үүсгэсэн нэвтрэх нууц үг, батлах нууц үгийн хамт Харилцагчийн Банканд бүртгүүлсэн баталгаат и-мэйл хаяг, утасны дугаарт илгээх ба Харилцагч Интернэт банкны эрхээрээ нэвтрэн орсны дараа нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг, батлах нууц үгийг өөрчлөх арга хэмжээг авна.
- 4.7. Интернэт банкны үйлчилгээгээр нэг өдөрт 20 сая төгрөг хүртэлх хэмжээний төлбөр тооцоо гүйцэтгэж болно. Энэхүү гүйлгээний хязгаар нь Банкны Ерөнхий нөхцөлөөр тодорхойлогдох ба Банк нь Ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулах замаар тухайн эрхийн хэмжээг нэг талын санаачлагаар өөрчилж болно.
- 4.8. Харилцагч Интернэт банкны гүйлгээний эрхийн хэмжээг интернэт банк болон салбарт хандан нэмэгдүүлэх хүсэлтээ гаргах боломжтой байна.
- 4.9. Интернэт банкны үйлчилгээний нууцлалын төхөөрөмж авах тохиолдолд Банкны салбарт өөрийн биеэр очиж үйлчлүүлнэ.
- 4.10. Интернэт банкны үйлчилгээгээр харилцагч нь өөрийн дансны мэдээллийг шалгах, тодорхой үнийн дүн бүхий төлбөр тооцоо гүйцэтгэх, хэрэглээний төлбөр төлөх, энэ гэрээнд заасан тодорхой төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ авах, тэдгээртэй холбоотой хүсэл зоригоо Банканд илэрхийлэх, холбогдох бүтээгдэхүүн үйлчилгээний хүсэлтэй танилцах зэрэг үйлчилгээг авч болно.
- 4.11. Интернэт банкны нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг, батлах нууц үг, и-код, и-токен төхөөрөмж зэрэг нь Харилцагчийн банкин дахь мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах, Харилцагчийн хүсэл зоригийн илэрхийллийг баталгаажуулахад хэрэглэгдэх баталгаат гарын үсгийн маягтын адил хүчин төгөлдөр байна. Харилцагч нь өөрийн нэвтрэх нууц үг болон батлах нууц үгийг хагас жил тутамд шинэчилж байна.
- 4.12. Харилцагч нь Интернэт банкны үйлчилгээний нэвтрэх эрхээ бусдад алдсан, нэвтрэх эрхийг бусад этгээд зөвшөөрөлгүй ашиглан Интернэт банк эсхүл Смарт банкаар хандалт хийсэн болохыг мэдсэн тохиолдолд энэ талаар Банканд нэн даруй мэдэгдэх үүрэг хүлээнэ.
- 4.13. Харилцагч нь өөрийн интернэт банкны нэвтрэх нэр, нууц үг, батлах нууц үгийг нууцлах, эдгээр мэдээллийг бусдад алдахаас сэргийлэх, баталгаат и-мэйл хаяг болон утасны дугаарыг бусдад ашиглуулахгүй байх хувийн мэдээлэлд өөрчлөлт оруулах боломжийг бусдад олгохгүй байх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс шалтгаалан Харилцагчид учирсан хохирлыг Банк хариуцахгүй.
- 4.14. Харилцагч нь Интернэт банкаар дамжуулан дараах бүтээгдэхүүн үйлчилгээг зайнаас авч болно. Үүнд:
 - 4.14.1. Ухаалаг утсанд зориулагдсан програм хангамжийн тусламжтайгаар интернэт банкны үйлчилгээ авах;
 - 4.14.2. Өөрийн харилцах болон хугацаагүй хадгаламжийн данснаас төлбөр тооцоо гүйцэтгэх – *нэг өдөрт гүйцэтгэх гүйлгээний хэмжээ нь хязгаарлалттай байх бөгөөд интернэт банкны эрхээс хамаарч 20-500 сая төгрөг хүртэлх хэмжээтэй байж болно;*
 - 4.14.3. Гадаад гуйвуулга хийх, арилжаа хийх;
 - 4.14.4. Захиалгат шилжүүлгийн даалгавар оруулах;
 - 4.14.5. Бүх төрлийн төлбөрийн карт шинээр захиалж авах, картын хугацаа сунгах, карт нөхөн авах тухай хүсэлт гаргах;
 - 4.14.6. Мобайл банкны үйлчилгээг идэвхжүүлэх;
 - 4.14.7. Сошиал пэй үйлчилгээнд бүртгүүлэх;
 - 4.14.8. Изи инфо үйлчилгээг идэвхжүүлэх;
 - 4.14.9. Энгийн харилцах данс нээлгэх;
 - 4.14.10. Бүх төрлийн картын харилцах данс нээлгэх;
 - 4.14.11. Хугацаагүй хадгаламжийн данс нээлгэх;
 - 4.14.12. Энгийн хугацаатай хадгаламж болон Хуримтлалын хадгаламжийн данс нээлгэх хүсэлт гаргах;
 - 4.14.13. Хугацаатай хадгаламжийн хугацааг сунгах;
 - 4.14.14. Өөрийн данс, төлбөр тооцооны мэдээллийг шалгах, хянах
 - 4.14.15. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ, салбар нэгжийн тухай мэдээлэл авах;
 - 4.14.16. Банкнаас үзүүлэх боломжтой гэж тодорхойлсон бусад бүтээгдэхүүн үйлчилгээ.

Смарт банк

- 4.15. Харилцагч нь өөрийн интернэт банкны нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан Банкны зүгээс ухаалаг утсанд зориулагдан бүтээгдсэн Смарт банкны програм хангамжийг ашиглан интернэт банкны үйлчилгээг авч болно.
- 4.16. Харилцагч нь Смарт банкны үйлчилгээг хэрэглэхдээ өөрийн ухаалаг утасны хурууны хээг унших үйлдлийг ашиглан Смарт банканд нэвтрэх орох боломжтой байна.
- 4.17. Смарт банкаар нэг өдөрт хийх гүйлгээний хязгаар, үйлчилгээний шимтгэл хураамж нь Банкны Ерөнхий нөхцөлөөр зохицуулагдана.

ТАВ. СОШИАЛ ПЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ

- 5.1. Банкны ухаалаг утсанд суурилсан Сошиал пэй програмаар дамжуулан Харилцагч нь бусад харилцагч нартай хувийн чат үүсгэн чатлах, өөрийн гар утасны дугаар, олон нийтийн сүлжээний хаягаар дамжуулан Голомт банкны данс хооронд төлбөр тооцоо гүйцэтгэх, өөрийн төлбөрийн картыг бүртгүүлж, дижитал хэлбэрээр картын төлбөр тооцоо хийх боломжтой.
- 5.2. Сошиал пэй програмаар дамжуулан үзүүлж буй зарим төрлийн үйлчилгээг Харилцагчийн утасны дугаар, Харилцагчийн хүчин төгөлдөр бичиг баримт, 4 оронтой нууц дугаар эсхүл Харилцагчийн хурууны хээгээр баталгаажуулна.
- 5.3. Харилцагч хүссэн тохиолдолд өөрийн интернэт банкны эрхтэй холбох боломжтой байна.
- 5.4. Харилцагч нь Сошиал пэй үйлчилгээгээр дамжуулан дараах бүтээгдэхүүн үйлчилгээг зайнаас авч болно. Үүнд:
 - 5.4.1. Сошиал пэй үйлчилгээнд бүртгэгдсэн гар утасны дугаар, и-мэйл Facebook, Twitter хаягаар дамжуулан Голомт банкны данс хооронд төлбөр тооцоо гүйцэтгэх – *нэг өдөрт гүйцэтгэх гүйлгээний хэмжээ нь хязгаарлалттай байх бөгөөд нэг өдөрт гүйцэтгэх боломжтой гүйлгээний хэмжээг Банкны цахим хуудсанд байршуулсан үйлчилгээний нөхцөлөөр тодорхойлно;*
 - 5.4.2. Сошиал пэй үйлчилгээнд бүртгэгдсэн гар утасны дугаар, и-мэйл Facebook, Twitter хаягаар дамжуулан бусадтай харилцах;
 - 5.4.3. Бүх төрлийн биет дебит карт болон биет бус дебит карт нээлгэх хүсэлт гаргах;
 - 5.4.4. Онлайн бүртгэлээр бүртгүүлсэн Харилцагч онлайн харилцах данс нээлгэх (Банканд харилцах дансгүй Харилцагч);
 - 5.4.5. Энгийн хугацаатай эсхүл Хуримтлалын хадгаламжийн данс нээлгэх;
 - 5.4.6. Банктай хамтран ажиллаж буй байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээг Сошиал пэй үйлчилгээгээр дамжуулан авах, тэдгээр үйлчилгээний төлбөрийг төлөх;
 - 5.4.7. Банкнаас үзүүлэх боломжтой гэж тодорхойлсон бусад бүтээгдэхүүн үйлчилгээ.

ЗУРГАА. МОБАЙЛ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

- 6.1. Харилцагчийн Банканд бүртгэлтэй гар утасны дугаарт суурилсан банкны төлбөр тооцоо гүйцэтгэх үйлчилгээг Мобайл банкны үйлчилгээ гэх бөгөөд тухайн үйлчилгээний хүрээнд дараах үйлчилгээ зайнаас авч болно. Үүнд:
 - 6.1.1. Өөрийн дансны мэдээллийг авах;
 - 6.1.2. Голомт банкны данс хооронд болон арилжааны бусад банкны данс руу гүйлгээ хийх – *нэг өдөрт гүйцэтгэх гүйлгээний хэмжээ нь хязгаарлалттай байх бөгөөд нэг өдөрт гүйцэтгэх боломжтой гүйлгээний хэмжээг Банкны цахим хуудсанд байршуулсан үйлчилгээний нөхцөлөөр тодорхойлно;*
 - 6.1.3. Картын төлбөр төлөх,
 - 6.1.4. Үүрэн телефоны оператор компанийн санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээг авах;
 - 6.1.5. Банкнаас үзүүлэх боломжтой гэж тодорхойлсон бусад бүтээгдэхүүн үйлчилгээ.
- 6.2. Мобайл банкны үйлчилгээгээр төлбөр тооцоо гүйцэтгэх тохиолдолд мобайл банкны нууц үгийг Харилцагчийн гарын үсгийн баталгаатай адилтгаж үзнэ.
- 6.3. Мобайл банкны нэг өдөрт хийх гүйлгээний хязгаар, үйлчилгээний шимтгэл хураамж зэрэг нөхцөл нь Банкны нийтэд ил тод зарласан, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Ерөнхий нөхцөлөөр тодорхойлогдоно.
- 6.4. Мобайл банкны үйлчилгээний шимтгэл, хураамжийн нөхцөл нь банкны нийтэд зарласан ерөнхий нөхцөлөөр тодорхойлогдоно.

ДОЛОО. КИОСК ТӨХӨӨРӨМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- 7.1. Харилцагч нь Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх боломжтой киоск төхөөрөмжөөр дамжуулан дараах бүтээгдэхүүн үйлчилгээг зайнаас авч болно. Үүнд:
 - 7.1.1. Өөрийн харилцах болон хугацаагүй хадгаламжийн данснаас төлбөр тооцоо гүйцэтгэх;
 - 7.1.2. Бүх төрлийн төлбөрийн карт шинээр захиалж авах, картын хугацаа сунгах, карт нөхөн авах тухай хүсэлт гаргах;

- 7.1.3. Мобайл банкны үйлчилгээг идэвхжүүлэх;
- 7.1.4. Изи инфо үйлчилгээг идэвхжүүлэх;
- 7.1.5. Энгийн харилцах данс нээлгэх;
- 7.1.6. Бүх төрлийн картын харилцах данс нээлгэх;
- 7.1.7. Хугацаагүй хадгаламжийн данс нээлгэх;
- 7.1.8. Энгийн хугацаатай хадгаламж болон Хуримтлалын хадгаламжийн данс нээлгэх;
- 7.1.9. Хугацаатай хадгаламжийн хугацааг цуцлах;
- 7.1.10. Өөрийн данс, төлбөр тооцооны мэдээллийг шалгах, хянах;
- 7.1.11. Хуулга, тодорхойлолт авах;
- 7.1.12. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ, салбар нэгжийн тухай мэдээлэл авах;
- 7.1.13. Банкнаас үзүүлэх боломжтой гэж тодорхойлсон бусад бүтээгдэхүүн үйлчилгээ.
- 7.2. Киоск төхөөрөмжөөр төлбөр тооцоо гүйцэтгэх тохиолдолд Банкны бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцөлийг баримтална.
- 7.3. Киоск төхөөрөмжөөр харилцах данс, хугацаагүй хадгаламжийн данс, Хуримтлалын хадгаламжийн данс нээлгэх тохиолдолд тухайн дансны дугаар болон бүтээгдэхүүний хүү шимтгэлийн нөхцөлийг тодорхойлсон Үйлчилгээний нэмэлт гэрээтэй танилцан баталгаажуулна.
- 7.4. Киоск төхөөрөмжөөр дамжуулан үйлчилгээ үзүүлэхдээ Харилцагчийн албан ёсны иргэний үнэмлэх болон бусад мэдээлэлд үндэслэн Харилцагчийг таньж, баталгаажуулна.

НАЙМ. ЛАВЛАХ ТӨВӨӨР ДАМЖУУЛАН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

- 8.1. Харилцагч нь өөрийн бүртгэлтэй гар утасны дугаараас Банкны албан ёсны лавлах утсанд холбогдож дараах бүтээгдэхүүн үйлчилгээг авах боломжтой. Үүнд:
 - 8.1.1. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээлэл авах;
 - 8.1.2. Банкнаас зарласан хөнгөлөлт урамшууллын мэдээлэл авах;
 - 8.1.3. Интернет банкны үйлчилгээ идэвхжүүлэх;
 - 8.1.4. Өөрийн Банканд бүртгэлтэй утасны дугаараас хандаж Мобайл банкны үйлчилгээг идэвхжүүлэх хүсэлт гаргах;
 - 8.1.5. Изи инфо үйлчилгээг идэвхжүүлэх;
 - 8.1.6. Банкны салбар нэгжийн байршил, цагийн хуваарийн тухай мэдээлэл авах;
 - 8.1.7. Банкнаас үзүүлэх боломжтой гэж тодорхойлсон бусад бүтээгдэхүүн үйлчилгээ.
- 8.2. Интернет банкны үйлчилгээ нээлгэх хүсэлтийг бүртгэлтэй утсаар хүсэлт гаргасан тохиолдолд Лавлах төвөөс Харилцагчийн мэдээллийг банкнаас тодорхойлсон сувгаар шалган баталгаажуулсны дараа Интернет банкны эрхийг нээж Харилцагчийн Банканд бүртгэлтэй утасны дугаар, и-мэйл хаягаар Интернет банкны нэвтрэх нэр, нууц үгийг хүргүүлнэ. Харилцагч нь шаардлагатай тохиолдолд банкнаас шаардсан баримтуудыг ирүүлэх бөгөөд холбогдох баримтуудыг ирүүлснээр интернет банкны үйлчилгээг энэ гэрээний 4 дүгээр зүйлд заасны дагуу мэдэгдэнэ.
- 8.3. Харилцагч нь энэхүү гэрээгээр дараах бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээллийг өөрийн Банканд бүртгэлтэй гар утасны дугаараар дамжуулан хүлээн авахыг зөвшөөрч байна. Үүнд:
 - 8.3.1. Бүх төрлийн харилцах, хадгаламж, зээлийн данстай холбоотой мэдээлэл үйлчилгээ;
 - 8.3.2. Дижитал сувгийн үйлчилгээнүүдийн тухай мэдээлэл болон тэдгээрийг ашиглах заавар;
 - 8.3.3. Бүх төрлийн дебит болон кредит картын үйлчилгээний мэдээлэл;
 - 8.3.4. Лавлах төвөөс боломжтой гэж тодорхойлсон бусад бүтээгдэхүүн, үйлчилгээ.
- 8.4. Харилцагч нь энэ гэрээний 8.3-т заасны дагуу банкнаас тодорхойлсон бүтээгдэхүүн үйлчилгээ авах хүсэлтийг банканд бүртгэлтэй мэйл хаяг, утсаар дамжуулан авах хүсэлт гаргаж болно.

ЕС. ЦАХИМ ХУУДСААР ДАМЖУУЛАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

- 9.1. Харилцагч нь Банкны www.cards.mn цахим хуудсаар дамжуулан дараах бүтээгдэхүүн үйлчилгээний хүсэлт гаргаж болно. Үүнд:
 - 9.1.1. Бүх төрлийн дебит карт шинээр захиалж авах;
 - 9.1.2. Кредит карт захиалах хүсэлтээ гаргах;
 - 9.1.3. Банкнаас үзүүлэх боломжтой гэж тодорхойлсон бусад бүтээгдэхүүн үйлчилгээ.
- 9.2. Харилцагч нь Банкны www.hurimtlal.mn цахим хуудсаар дамжуулан дараах бүтээгдэхүүн үйлчилгээний хүсэлтийг Банканд гаргаж болно. Үүнд:
 - 9.2.1. Хуримтлалын хадгаламжийн данс нээлгэх хүсэлт гаргах.

АРАВ. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

10.1. Харилцагч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 10.1.1. Энэхүү гэрээ болон түүнд олгосон гарын авлага, Банкны цахим хуудсаар мэдэгдсэн Банкны ерөнхий нөхцөл, төлбөр тооцооны цагийн хуваарь, санамж, заавар, хүсэлт, сонголтууд болон бусад мэдээлэлтэй нарийвчлан, бүрэн танилцаж, шаардлагатай тохиолдолд банкны ажилтнаас нэмэлт мэдээлэл авах, эдгээр материал, мэдээлэл болон энэхүү гэрээнд нийцүүлэн үйлчилгээ авах;
- 10.1.2. Дижитал сувгаар хийх гүйлгээний мэдээлэл, төлбөр хүлээн авагчийн нэр, дансны дугаар, гүйлгээний утга, мөнгөн дүн зэрэг төлбөрийн мэдээллийг нарийвчлан нягталж гүйлгээ хийх үүрэгтэй;
- 10.1.3. Интернэт банкаар үйлчлүүлэх тухай хүсэлт, Банкнаас шаардсан бүрдүүлэх материалыг үнэн зөв бөглөж, бүрдүүлж Банканд хүлээлгэн өгөх;
- 10.1.4. Интернэт банкны тусгай эрх авах тохиолдолд Банкны аль нэг салбарт хүрэлцэх ирж, “Тусгай эрхтэй интернэт банкны үйлчилгээний санамж”-тай танилцаж баталгаажуулах үүрэгтэй;
- 10.1.5. Интернэт банкаар үйлчлүүлэх анхны оролдлогоор Банкнаас өгсөн нууц үгийг солих;
- 10.1.6. Зайны сувгаар бүтээгдэхүүн үйлчилгээ авахад хэрэглэж буй нууц үгийг тогтмол сольж байх, нууц үгийг солихдоо Банкнаас өгч буй зөвлөмжийн дагуу тоо, үсэг, тэмдэгт холилдсон өндөр нууцлал бүхий нууц үг сонгож хэвших;
- 10.1.7. Зайны сувгаар бүтээгдэхүүн үйлчилгээ авахад хэрэглэж буй и-мэйл хаяг, утасны дугаар, интернэт банкны нэвтрэх нэр, нууц үг, нууцлалын төхөөрөмж, бусад үйлчилгээний нууцлал зохих мэдээллийг бүрэн нууцлах үүрэгтэй ба эдгээр мэдээллийг бусдад алдахаас сэргийлэх, бусдад сайн дураараа дамжуулахгүй байх үүрэгтэй бөгөөд мэдээллийг алдсан тохиолдолд нэн даруй Банкны лавлах 1800-1646 дугаарын утсаар, эсвэл банкны салбарт биечлэн ирж мэдэгдэн, үйлчилгээний эрхээ түр хаалгах, бичгээр өргөдөл гаргах үүрэгтэй ба түүнээс шалтгаалан бий болох аливаа үр дагаврыг бүрэн хариуцах;
- 10.1.8. Зайны сувгаар бүтээгдэхүүн үйлчилгээ авахад хэрэглэж буй аливаа мэдээллийг бусдад алдсан эсхүл алдсан байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай Банканд нэн даруй мэдэгдэх;
- 10.1.9. Зайны сувгаар дамжуулан илэрхийлсэн хүсэл зоригоо холбогдох нөхцөлийн дагуу баталгаажуулсан тохиолдолд түүнээс шалтгаалан бий болох аливаа үр дагаврыг хариуцах;
- 10.1.10. Зайны сувгаар дамжуулан үйлчилгээ авахад ашиглаж буй төхөөрөмж, програм хангамж, интернэт сүлжээ, гар утасны сүлжээний аюулгүй байдал, хэвийн ажиллагаанд хяналт тавих;
- 10.1.11. Зайны сувгаар хийгдсэн төлбөр тооцооны мэдээллийг тогтмол хянаж байх;
- 10.1.12. Зайны сувгаар дамжуулан төлбөр тооцоо хийхдээ гүйлгээний мэдээллийг үнэн зөв оруулж, үнэн зөв оруулсан эсэхийг нягтлан шалгасны үндсэн дээр гүйлгээ хийх;
- 10.1.13. Өөрийн хувийн мэдээлэлд өөрчлөлт орсон бол энэ тухай Банканд нэн даруй мэдэгдэж, тухайн өөрчлөлтийг баталгаажуулахад шаардлагатай албан ёсны баримтыг Банканд гаргаж өгч байх;
- 10.1.14. Харилцагч өөрийн бүртгэлтэй утасны дугаар, и-мэйл хаяг өөрчлөгдсөн тохиолдолд Интернэт банк, Смарт банк, Сошэйл пэй үйлчилгээгээр дамжуулан эсхүл Банкны аль нэг салбар тооцооны төвд хандаж нэн даруй шинэчилж байх үүрэгтэй;
- 10.1.15. Харилцагч бүртгэлтэй дугаар, мэйл хаягаа шинэчлэгдсэн даруйд банканд хандаж мэдэгдээгүйн улмаас үүсэх аливаа эрсдэлд банк хариуцлага хүлээгүй.
- 10.1.16. Интернэт банкны үйлчилгээгээр төлбөр тооцоо гүйцэтгэх тохиолдолд дижитал хэлбэрээр хүргүүлж буй санамж, заавартай сайтар танилцаж, нэг бүрчлэн биелүүлж байх;
- 10.1.17. Дижитал сувагт нэвтэрч Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэсний дараа үйлчилгээнээс бүрэн гарч хэвших.

10.2. Харилцагч дараах эрх эдэлнэ. Үүнд:

- 10.2.1. Энэхүү гэрээ болон Банкны нийтэд зарласан ерөнхий нөхцөлийн дагуу зайны сувгаар дамжуулан Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ авах;
- 10.2.2. Өөрийн хүсэлтээр энэхүү гэрээг цуцлах, зайны сувгаар дамжуулан бүтээгдэхүүн үйлчилгээ авахаас татгалзах
- 10.2.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Банкнаас шаардах;
- 10.2.4. Цахим сувгаар хийсэн гүйлгээний баримт болон бусад хэлбэрээр зайнаас үзүүлсэн бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээллийг Банкнаас гаргуулан авах. Шаардлагатай тохиолдолд гүйлгээний баримтыг Банкны салбар тооцооны төвөөс баталгаажуулж авах;
- 10.2.5. Зайны сувгаар дамжуулан гүйцэтгэсэн төлбөр тооцоог Банканд хандаж баталгаажуулан шалгуулах.

10.3. Банк нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 10.3.1. Харилцагчийн Банканд бүртгэлтэй мэдээллийг нууцлах;

- 10.3.2. Харилцагчийн өгсөн хүсэлтийн дагуу энэ гэрээ болон Банкны нийтэд зарласан нөхцөл, журмын дагуу Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг зайнаас үзүүлнэ;
 - 10.3.3. Зайны сувгаар үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөл, журмыг Харилцагчид нээлттэй байдлаар харуулах бөгөөд Харилцагчийн хүсэлтийн дагуу нэмэлт мэдээллийг тухай бүр гаргаж өгөх үүрэгтэй;
 - 10.3.4. Зайны сувгаар үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний талаар холбогдох гарын авлага, мэдээллийг холбогдох сувгаар Харилцагчдыг тогтмол хангах үүрэгтэй;
 - 10.3.5. Зайны сувгаар үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдлыг ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэж, хариу өгч байна. Хоёр буюу түүнээс дээш дамжлагаар шийдвэрлэгдэх, бусад хугацаа шаардсан өргөдөл, гомдлын хариуг боломжит хугацаанд багтаан өгч байх.
- 10.4. Банк дараах эрх эдэлнэ. Үүнд:
- 10.4.1. Зайны сувгаар үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний шимтгэл, хураамжийг Банкны нийтэд зарласан ерөнхий нөхцөлийн дагуу Харилцагчийн данснаас үл маргах журмаар суутгах;
 - 10.4.2. Харилцагч нь зайны сувгаар бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг хангаж чадаагүй тохиолдолд зайны сувгаар үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;
 - 10.4.3. Харилцагчид зайны сувгаар бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх нь эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд энэ талаар Харилцагчид зохих тайлбарыг өгч зайны сувгаар үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;
 - 10.4.4. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд, Банкны болон Харилцагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор зайны сувгаар бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэхийг түр зогсоох;
 - 10.4.5. Нийтэд зарласан бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлийг энэхүү гэрээнд заасан журмын дагуу өөрчлөх.

АРВАН ХОЁР. БУСАД

- 11.1. Энэхүү гэрээ нь талуудын гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 11.2. Энэхүү гэрээ нь Харилцагч болон Банкны хооронд байгуулагдсан Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх гэрээний салшгүй хэсэг байна.
- 11.3. Энэхүү гэрээний дагуу байгуулсан Үйлчилгээний нэмэлт гэрээнүүд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

Банкийг төлөөлж:

Овог, нэр:(DOMAIN)

Гарын үсэг:.....

(Тэмдэг)

Харилцагч:

Овог, нэр:

Баталгаат гарын үсэг: